

COVID-19-ийн талаар сурагчдын ар гэр бүлд зориулсан зөвлөмж

2021 оны 6 сард шинэчлэв

Бид Австралийн Эрүүл Мэндийг Хамгаалах Төв Хороо (Australian Health Protection Principal Committee (AHPCC)) болон NSW муж улсын Эрүүл мэндийн яам, бусад агентлагуудтай нягт хамтран ажиллаж байгаа бөгөөд COVID-19-ийн дэгдэлт бүхий энэ орчинд манай бүх сургуулиуд сурагчдынхаа суралцах орчны аюулгүй байдлыг хамгийн дээд зэргээр хангасан байхыг зорьж ажиллаж байна.

NSW мужийн Эрүүл мэндийн Яамнаас гаргасан шинэчилсэн зөвлөмж

COVID-19-ийн дэгдэлтийн талаарх мэдээллийг бид байнга шинэчлэн мэдээлж байгаа бөгөөд сурагчдын ар гэрийнхэнд NSW муж улсын засгийн газрын цахим хуудас ([NSW Government website](#))-ыг байнга шалгаж байхыг зөвлөж байна.

COVID-19-ын дэгдэлттэй холбоотойгоор NSW муж улсын Эрүүл мэндийн Яамнаас гэртээ байх тушаал гаргасан үед сургуулийн хичээлийн явцад өөрчлөлт гарах боломжтой. Эдгээр өөрчлөлтүүдийн талаар сургуультай холбоо барин асуухыг бид зөвлөж байгаа бөгөөд сургуулийн ажилтан албан хаагчдаас өгөх онц хүндэтгэх шалтаангүйгээр сургуульд нэвтрэхийг хориглосон заавар зөвлөгөөг даган мөрдөнө үү.

Гэрээсээ суралцах нь

Доорх нөхцөл байдалд сурагчдыг [гэрээсээ суралцахыг](#) сургуулиас зөвшөөрөх болно:

- COVID-19-оор халдварласан нь тогтоогдсон, эсвэл халдварласан байх магадлалтай хүнтэй ойрын хавьталд орсон шалтгаанаар өөрийгөө тусгаарлах шаардлагатай болсон бол
- COVID-19-ийн дэгдэлтээс шалтгаалан нэн шаардлагатай мэргэжлийн ажилчин, албан хаагчдын хүүхдүүдийг сургууль дээр хичээллүүлэх шаардлагатай гэсэн Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан захирамж гарсан бол

Гэрээсээ суралцах нь олон төлөв байдалтай байж болох юм. Үүнд онлайн болон офлайн эх сурвалжуудыг ашиглах, хэвлэмэл материал, мэдээлэлтэй ажиллах гэх мэт.

Сургууль дээр танхимын хичээл орж буй үед сурагчдыг сургуульд явуулах талаар зөвлөмж

NSW Эрүүл мэндийн Яамны зөвлөмжийн дагуу, бие нь тааруу, эсвэл ялимгүй ч гэсэн томуу төст өвчний шинж тэмдэг илэрч байвал хүүхдээ сургуульд **ЯВУУЛАХГҮЙ** байхыг эцэг эхчүүд, асран хамгаалагч нарт сануулж байна.

Өвчтэй эсвэл ханиад, томуу өвчний ялимгүй ч гэсэн шинж тэмдэгтэй сурагчийг өөрийн өрхийн эмчээрээ дамжуулан эсвэл орон нутгийнхаа COVID-19-ийн эмнэлэг ([COVID-19 clinics](#))-т очин шинжилгээ өгөхийг сургуулиуд хүсч байхыг NSW муж улсын Эрүүл мэндийн Яам зөвлөмж болгосон болно.

Сургууль дээр танхимын хичээл орж буй үед сурагчдыг сургуульд явуулах талаар зөвлөмж (үргэлжлэл)

Ханиад, томуу өвчний шинж тэмдэг илэрсэн багш, ажилтан, сурагчид COVID-19 шинжилгээнд хамрагдах ёстой бөгөөд уг шинжилгээний сөрөг гарсан хариуг сургуульдаа өгсөн, мөн уг өвчний ямар нэгэн шинж тэмдэггүй байгаа үед л сургуульд буцаж ирэхийг зөвшөөрнө.

COVID-19-ын шинжилгээнд хамрагдаагүй сурагчдыг 10 өдөр сургуульд ирэхийг хориглоно. Үүнээс гадна сурагч нь сургуульд ирэхээс өмнө хамгийн багадаа 3 өдөр уг өвчний шинж тэмдэггүй байсан байх ёстой.

Улирлын чанартай аллергит ринит гэх мэт томуу, томуу-төст өвчний шинж тэмдэг бүхий сурагчид COVID-19-ийн шинжилгээнд хамрагдах ёстой бөгөөд мөн сөрөг хариу авсан тохиолдолд сургуульд ирэх боломжтой. Эдгээр өвчний шинж тэмдэгтэй сурагчид уг шинж тэмдэг нь 10-аас илүү өдөр үргэлжилсэн бол өөрийн эмчээсээ уг сурагчийн уг өвчний шинж тэмдэг юм гэдгийг баталсан албан бичигтэй байж сургуульд ирж суралцах боломжтой. Хэрэв тухайн сурагчийн өвчний шинж тэмдэг өөрчлөгдөх буюу шинээр шинж тэмдэг илэрвэл COVID-19-ийн шинжилгээ өгвөл зохино. COVID-19 өвчний шинж тэмдгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг олж харна уу ([COVID-19 symptoms](#)).

Хөгжлийн бэрхшээлтэй болон эрүүл мэндийн нарийн төвөг бүхий асуудалтай сурагчдыг COVID-19-ийн шинжилгээнд хамруулах нь ярвигтай байж болох юм. Ийм тохиолдолд тухайн сурагчийг мэргэжлийн эмнэлгийн байгууллагаар тодорхойлуулах хүсэлтийг сургууль гаргаж өгөх болно. Мэргэжлийн эмч уг хүүхдийг COVID-19-ийн шинжилгээнд хамруулах албагүй хэмээн тодорхойлсон бол үүнийг нотолсон баримтыг сургуульд өгөх ёстой. Уг баримт нь тухайн сурагчийг COVID-19-ийн шинжилгээнд хамруулахад хүргэх шинж тэмдэг байхгүй гэдгийг харуулсан байхаас гадна тухайн сурагчийг сургуульд буцан ирж суралцаж болно гэдгийг баталсан байх ёстой.

Бүх сургууль болон гэр бүл ард иргэдэд өгөх санамж

Сургууль болон сурагчын ар гэр бүлийнхэн COVID-19-ийн хөл хорионы зохих зөвлөмж заавруудыг даган мөрдөх нь маш чухал. Ялангуяа доорх зааврыг дахан мөрдөнө үү:

- Сургуулиуд доорх журмыг баримтлана:
 - Хувийн ариун цэвэр сахих нөхцлийг бүрдүүлсэн, зай барих журмыг хэрэгжүүлсэн, ариутгал цэвэрлэгээ болон бүртгэл хөтлөлтийг зохих журмаар явуулсан байх
 - Бололцоотой бол цаг агаарын таатай үед сургуулийн гадаа задгай талбайг аль болох ашиглах, ингэснээрээ зай барих журмыг хэрэгжүүлэх хангалттай нөхцөлийг бүрдүүлсэн байх
 - Сургууль дээр ирж буй бүх зочид, гэрээт ажилчид болон үйлчилгээ үзүүлэгч албан хаагчдыг зохих журмын дагуу бүртгэн авч [COVID-19-ийн дэгдэлттэй холбоотой тавигдах шаардлагыг](#) даган мөрдөнө гэсэн амлалтыг сургуульд нэвтрэх бүрт гаргуулан авахаас гадна тэдгээр зочид, албан хаагчид уг өвчний шинж тэмдэггүй байхыг магадласан байх. Бүх зочдын ирцийг Service NSW QR code-г ашиглан бүртгэсэн байх. Хүүхдээ сургуульд хүргэж өгөх болон тосон авч буй эцэг эчүүд, асран хамгаалагч нар Service NSW QR code-оор бүртгүүлэх албагүй.

Маск зүүх болон халуунаа шалгуулах

Сургууль дээр өөрийн маскаа зүүхийг сурагчдад зөвшөөрнө.

Эрүүл мэндийн байгууллагын шаардлагын дагуу бүх иргэд олон нийтийн тээврийн хэрэгслээр зорчихдоо маск зүүх ёстой гэсэн журмыг хэрэгжүүлж буй үед 13 буюу түүнээс дээш насны сурагчид энэхүү журмыг даган мөрдөх ёстой. Сургуулийн ажилчид, албан хаагчид мөн энэ журмыг даган мөрдөх ба нийтийн унаа болон хувийн тээврийн хэрэгслээр сургуулийн аялал хийхдээ ч мөрдөх ёстой.

Сургуулиудад сурагчдын биеийн халууныг шалгах албан шаардлага тавигдахгүй байгаа болно.

Сургуулийн цэвэрлэгээ болон ариун цэврийн багаж хэрэгслийн хангамж

АНППС-ийн журам болон NSW муж улсын Эрүүл мэндийн Яамнаас гаргасан зөвлөмжийн дагуу танай сургуульд ариун цэврийн нэмэлт цэвэрлэгээ хийгдэх болно. Цэвэрлэгээг хүний гар ихээр хүрдэг гадаргуудад, тухайлбал хаалганы бариул, хувцасны шүүгээ, гэрлийн унтраалга, шатны бариул гэх мэт цэгүүдийг онцгойлон анхаарч гүн цэвэрлэгээ хийх болно. Мөн сургуулийн ариун цэврийн өрөө болон усны цоргыг нэмэлт цэвэрлэгээнд хамруулж саван гэх мэт материалын хангамжийг нэмэгдүүлнэ.

Сургуулиуд шингэн саван, гар ариутгагч, цаасан алчуур, гадаргуу ариутгагч гэх мэт ариун цэврийн хэрэгслээр байнга хангагдах болно.

COVID-19-ийн дэгдэлт гарсан үед авах хариу арга хэмжээ

Сургуулиудад COVID-19-ын дэгдэлт гарч болзошгүй, эсвэл дэгдэлт гарсан нөхцөлд сургуулиуд ямар журмыг мөрдөх вэ гэдгийг тодорхой болгон бэлтгэсэн байгаа болно. Бид NSW муж улсын Эрүүл мэндийн Яамтай нягт хамтран ажиллаж байгаа бөгөөд ийм тохиолдолд сургуулийн зүгээс эцэг эхчүүдтэй холбогдох болно. Уг өвчний дэгдэлтийн үед мөрдвөл зохих COVID-19-ийн дэгдэлтийн үеийн Журам ([Response protocols for COVID-19 cases](#))-ын талаар нэмэлт мэдээлэлтэй танилцана уу.

Нийтийн тээвэр, унаа

Сурагчдыг тээвэрлэх сургуулийн автобусны үйлчилгээ хэвийн үргэлжлэх болно. Сургууль гэрийн хоорондох автобусны үйлчилгээний талаарх нэмэлт мэдээллийг NSW мужийн Тээврийн яам ([Transport for NSW](#))-тай холбогдоно уу.

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл сургуулийн захирал руу залгаарай. Хэрвээ танд орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний Төвтэй 131 450 дугаараар холбогдон өөрийн хэлний орчуулагчтай холбож өгөхийг хүсээрэй. Энэхүү үйлчилгээ нь үнэ төлбөргүй болно.